

Монголчуудын хүрээлэн буй орчны ёс суртахууны үндэс: байгаль шүтлэгийн домог

Сүхбатын Соёлмаа, доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс

soyolmaas@mas.ac.mn; <https://orcid.org/0000-0002-3181-6948>

Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-25

Published : 2024-12-20

Түлхүүр үгс

хүрээлэн буй орчин,
ёс суртахуун,
байгаль,
шүтлэг, домог

Keywords

speech, medium,
Mahayana,
consciousness,
existence,

© The Author(s), 2024



Хураангуй: Энэхүү өгүүлэлдээ бид монголчуудын хүрээлэн буй орчны ёс зүйн үндэс болсон байгаль шүтлэгийн домгуудыг нэр томъёоны гарвал зүй, структурализм, шашин соёлын орчин үеийн философийн үүднээс шинжлэн судалсан зарим үр дүнг тоймлов. Ингэхдээ домгийг байгаль, соёлын ялгааг арилгах, бурханлиг болон хүний нийгэм хоорондын зуучлагч, хүний хүсэл мөрөөдлийг биелүүлэх хэрэгсэл гэж үзэв. Хэлэлцүүлгийн хэсэгт байгаль шүтэх домгийг ургамал, газар шороо, уул ус, ан амьтан, тэнгэрийн домог гэж ангилсан юм. Байгаль шүтлэгийн Монголчуудын домог нь орчин үеийн хүрээлэн буй орчны асуудлыг шийдвэрлэхэд анхаарах ёстой итгэл үнэмшил, мөрөөдлийн тогтолцоо юм.

Mongolians' environmental ethics: nature worship myths

Soyolmaa Sukhbat (Ph.D)

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia, soyolmaas@mas.ac.mn;

<https://orcid.org/0000-0002-3181-6948>

Abstract: This paper selects and analyses Mongolian myths of nature worship, the basis of Mongolian environmental ethics, using etymology, structuralism, modern religion and culture philosophy. When studying the myth of nature worship, myths are regarded as a means of overcompensating the contradictions between nature and culture, facilitating God and human society, and achieving the dreams of people. In this way, myths about the worship of nature have been classified as myths about plants, land, mountains, animals, water and the sky. Mongolian environmental ethics is the basis of the mythical thinking of natural worship, and modern environmental problems need to take into account the belief and dream system.

I. Оршил

Тус өгүүллийн гол зорилго бол монголчуудын хүрээлэн буй орчны ёс суртахууны үндэс болсон байгаль шүтлэгийн домгийг орчин үеийн соёл, шашин, домог зүйн философийн

үүднээс жишиг болгож, шинжлэхэд оршиж байна.

Өрнийн болон Оросын олон эрдэмтэн судлаачид хүрээлэн буй орчны тухай Монголчуудын ойлголт, ёс суртахууны тухай бичсэн байдаг.

Үүний анхдагч эхлэлийг бид XIII зууны үед Монголд ирсэн Плано Карпини, Вильгелм Рубрук, Марко Поло гэх мэт өрнөдөөс дорно руу аялсан жуулчдын тэмдэглэлүүдээс харж болох юм. Монголын одоогийн газар нутаг орны байр байдлын тухай энд өгүүлэхдээ «... энэ газар нутгийн лав зууны нэг хувь нь үржил шимгүй бөгөөд гол горхины усаар услахгүй л бол ургац өгч чадахааргүй ажээ... Газар нутаг нь ийнхүү үржил шим муутай, мал адуулахад дэндүү таатай биш ч гэсэн ямар ч атугай боломжийн тохирох нутаг ажгуу» (Дель Ж., Плано Карпини, Вильгелм де Рубрук., 1988) гэсэн байна. Энд эдгээр аялагчид тухайн үед амьдарч байсан Монголчуудын газар нутгийг тариалан эрхлэхэд тийм ч тохиромжтой биш ч мал аж ахуй эрхлэхэд боломжийн газар орон, мөн эрс тэс шинжтэй гэдгийг онцолсон нь харагдаж байна. Мөн Марко Поло аялалынхаа тэмдэглэлд «Татарууд хэзээ ч зогсдоггүй. Өвлийн улиралд өвс ургамал сайтай, малын бэлчээртэй тэгш, ээвэр дулаан газар өвөлжих ба зундаа усны тунгалаг, бэлчээрийн соргогийг даган сэрүүн ууланд зусах ажээ» (Рамузио. 2019, 65) хэмээн Монголын газар нутгийн уур амьсгал, газар нутгийн онцлогийн тухай өгүүлсэн байна. Үнэхээр ч Монголчууд мал маллан нүүдэллэн амьдрахдаа тийм ч хол газар нүүдэггүй бөгөөд жилийн 4 улиралд очиж суудаг хоёроос гурван газартай л байдаг. Зун болохоор арай сэрүүхэн, устай ойр газар бууж, өвөл нь уулын ээвэр нөмөрт амьдарсаар ирсэн юм. Одоо ч энэ нь Монголын малчдын нүүдэллэн амьдрах онцлог байсаар байна. Тухайлбал, эрт дээр үеэс Монгол угсаатнуудын дунд дэлгэрч ирсэн Гэсэр хэмээх туульд гол баатар өмнө

зүгээс умард, дараа нь умардаас өмнө зүгт гэсэн чиглэл бүхий үйлдлүүдийг гүйцэтгэдэг.

Ийнхүү өрнөдийн эрдэмтэд Монголчуудын хүрээлэн буй орчны ёс суртахууныг судалж эхэлсэн үе нь XIII зуунаас эхлэлтэй бөгөөд үүнээс хойш 20 дугаар зуунд зөвлөлт Орос улсын эрдэмтэд судалж ном бүтээл туурвисны нэг жишээ бол С.Ю.Неклюдов, Е.М.Мелетинский нарын бүтээл юм. Ялангуяа, Неклюдов бол монголчуудын домог аман зохиолын уламжлалыг бүтэц-тэмдэг зүйн аргаар судалсан томоохон эрдэмтэдийн нэг юм. Францын угсаатан судлаач, социологич Марсель Мосс нь Монголчуудын шашны домгийн дүрүүдийн тухай “Дээд ариуны нийгмийн үүргүүд” гэсэн бүтээлдээ, тухайлбал, буддизмын дүрүүдийн тухай эмпирик баримтууд бүхий номыг А.Грюнведель бичсэн (Марсель Мосс. 2000, 378) тухай өгүүлсэн байна. Мөн Мосс энд бичихдээ буддизм хэзээ ч хаалттай соёл байгаагүй, харин илүү нээлттэй, тухай орон нутгийнхаа шүтдэг дүрүүдтэй үргэлж нэгдэн нийлж, холимог байдлаар оршиж ирсэн тухай бичсэн байна. Жишээ нь, тэрээр бичихдээ “Тэр Төв Азийн олон бурхдуудыг өөртөө багтаадаг. Тухайлбал, Нагчуудын шүтээнийг (могой, усны эзэд), цус сорогч эсвэл “ветал”-уудын, химер шувууд эсвэл “гаруд”-уудыг гэх мэт. Ийнхүү энэ бүхэн нэгэн цулд нэгдэж байдаг” (Марсель Мосс. 2000, 379) гэсэн байна.

Эрдэмтэн, философич Ч.Жүгдэр нь “Монголын нийгэм-улс төр, философи сэтгэлгээний хөгжил (МЭӨ III-МЭ XX зуун)” гэсэн бүтээлдээ монголчуудын хүрээлэн буй орчны ёс зүйн тухай товч авч үзсэн байдаг. Тэр “Эртний Монголчууд нэг талаар,

байгальтай тэмцэл хийж түүнийг ялан давах арга ухаан сүвэгчлэхийн хамт нөгөө талаар, түүний эрхшээлд автаж арга мухардахдаа байгалийг шүтэж, эзэд онгод гэгчийг бишрэх болжээ” (Жүгдэр Ч. 2006, 35) хэмээн Монголчуудын хүрээлэн буй орчны ёс суртахууны тухай Марксист философийг баримталж өгүүлсэн байна.

II. Судалгааны арга зүй

Хүрээлэн буй орчны ёс суртахуун хэмээх ойлголтыг этимологийн үүднээс дараах утгаар авч үзсэн болно. Монгол хэлний ёс суртахуун буюу орос.мораль (лат. *moralitas*), англ. *morality* хэмээх нь «ёстойн ба дээд үнэт зүйлсийн хүрээг нэгтгэн илэрхийлэх, европын философийн ойлголт юм» (Института философии, РАН., 2024) хэмээн тодорхойлсон байна. Харин монгол хэлний зан суртахуун, орос хэлний нравственность (лат. *mos*, олон тоон дээр. *mores*), англи хэлний “characteristics” гэсэн үгийг ёс суртахуун хэмээх үгтэй ижил утгаар орчуулж, хэрэглэсээр иржээ. Мөн үгийн гарал үүслийн хувьд орос хэлний “нрав”, “характер” зэрэг зан араншин, зан суртахуун, зан үйл зэрэг утгуудыг агуулдаг. Мөн ном, судалгааны бүтээлүүд дээр энэ хоёрын араас суртахуун хэмээн бичээд нэг их ялгахгүйгээр хольж сольж бичсэн нь цөөнгүй юм. Иймээс эдгээр ойлголтыг ялгаж авч үзэх нь зүйтэй юм. Тухайлбал, зан гэдэг бол 1. *Хүн амьтны аашлах байдал төлөв*, 2. *Ая, үйл ажил гэсэн утгатай бол харин зан суртахуун хэмээхийг ямар нэгэн нийгэмлэгийн шаардлагад тохирох хүний ааль авир, дүрэм, төлөв* (Цэвэл Я. 1966, 265) гэж тодорхойлжээ. Харин ёс хэмээхийг 1. *Юмны зайлшгүй зүй тогтол, жам*

тавилан, 2. *Хүний дагаж баримтлах хэв хууль, журам зарчим, заншил суртал гэсэн бол харин ёс суртахууныг хэвшсэн тогтсон зан суртал* (Цэвэл Я. 1966, 237) гэсэн байна. Дээрх утгаас дүгнэхэд зан суртахуун хэмээх нь хувь хүний нийгэмлэгийн шаардлагад тохирсон байдаг бол ёс суртахуун хэмээх нь нийгмийн хууль зүй тогтол гэсэн утгатай байж болох юм. Гэхдээ эдгээр ойлголтын ерөнхий утга нь тогтсон хэв ёс юм. Тиймээс бид ёс суртахуун гэсэн ойлголтыг нийгмийн шинжтэй гэдэг утгаар нь авч хэрэглэж байна. Харин хүрээлэн буй орчны ёс суртахуун хэмээх нь хүн ба түүний бүтээсэн соёл, иргэншлийн зүгээс байгалийн хязгаарлагдмал нөөц баялагийг хэмнэж амьдрах, мөн хувь хүн, нийгэм, байгаль гэсэн гурван талт субъектын тогтвортой, нийцтэй, шударгаар орших эрхийг хангахыг зорьж буй хүнлэг үзэл санаа, хандлага, хүсэл мөрөөдөл, үйлдлийн цогц юм.

Бид байгаль шүтлэгийн домгийг сонгон судлахдаа структурализм, соёлын философийн төлөөлөгч М.Элиаде, америкийн философич, гоо зүйч С.Лангер нарын философийг баримталсан болно. С.Лангер бичихдээ “Домог бол үлгэр шиг хүсээд орхих, үл гүйцэлдэх үзлийн шинжтэй бус, харин хүссэн зүйлээ биелүүлэхийн төлөөх тэмцэл, зөрчил өрнөсөн эмгэнэлт шинжтэй хүүрнэл юм” (Susanne Langer. 1942, 142) гэсэн байна. Структурализмын үүднээс бол домог нь байгаль ба соёл гэсэн эсрэгцлийг давж туулах логик арга хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, домог бол хүн, түүний бүтээсэн соёл, иргэншлийн зүгээс байгалийг захирах эсвэл эрхшээлдээ оруулж ашиглах гэх эсрэг байр суурийн үүднээс бус, харин байгальтай зохицож, нийцтэй амьдрах,

түүнийг субъект байдлаар хүндэтгэх гэсэн эко ёс суртахууны үүд хаалга, гүүр нь болж байна. Харин Элиадегийн үзлээр домог бол энэ ертөнцийн ариун, ер бусын янз бүрийн зүйлийг, зарим үед эрчим хөдөлгөөнтэй, хүчтэй илрэлийг дүрсэлдэг (Элиаде Мирча. 1995, 15) юм. Мөн байгаль шүтлэгийн домгийг Монголын аман зохиол, домог судлаачдын домгийн эмхэтгэл цуглуулгын бүтээлүүдээс түүвэрлэн авсан болно. Домог бол ард түмнүүдийн өдөр тутмын зан амьдралтай хамгийн ойр зүйл бөгөөд учир юу вэ гэвэл энэ нь тухайн ард түмний үнэн хүсэл мөрөөдөл, анхдагч дүр билээ. Хүсэл мөрөөдөл, төсөөлөл бол хүмүүсийн өдөр тутмын амьдралын гол түлхэгч хүч юм. Тийм учраас бидний энэ удаагийн өгүүллийн гол таамаглал бол Монголчуудын хүрээлэн буй орчны ёс зүйн үндэс нь хүсэл мөрөөдлийн биелэл, байгаль шүтлэгийн домог болох тухай юм.

III. Судалгааны үр дүн

Бид Монголчуудын байгаль шүтлэгийн домгийг судалж, улмаар дараах үр дүнд хүрсэн болно. Ингэхдээ байгаль шүтлэгийн домгийг байгалийн элементүүдийг шүтэж буй хэлбэрээр нь ургамал, газар, уул, амьтан, ус, тэнгэр гэх мэт ангилан авч үзлээ.

Ургамал шүтлэгийн домог. Арц мод мөнх ногоон болсон тухай: *Балар эрт цагт Мисир нэрт балгасанд Сулхарнай гэгч хүн мянга наслан сууж байв. Тэр хүн тэнгэрт залбирч мөнхийн ус эрж явтал харанхуй нүхний амсарт хүртэл, нэгэн хүн биеэ үл үзүүлэн цөгц дүүрэн ус өгч хэлсэн нь: Сулхарнай чи тэнгэрт соёрхогдож 3000 наслав. Хэрэв энэ усыг ууваас тэнгэр газар хувилтал үл үхэн мөнх наслах болно гэв...Сулхарнай цөгцтэй*

усыг гадагш авч гарч урт наслуулах энэ усыг уух уу яах вэ гэж зөвлөхөд... Тэгтэл тэндээс нэг сэцэн хүн ингэж хэлэв. Энэ усыг уугаад тэнгэр газар хувилтал үл үхэн маш удаан наслахад чиний садан төрөл чинь цөм үхэж дүүрэхэд чи ганцаар амьд явах ямар тус байх вэ? Энэ усыг би юу гэж уув даа гэж өөрөө гэмших цаг чамд ирнэ гэхэд Сулхарнай энэ үгийг сонсоод гартаа барьж байсан цөгцтэй усыг сацаж орхитол тэр нь арц модны навчин дээр тусч үүнээс хойш арц мод өвөл зун үл хувирах мөнх ногоон өнгөтэй болсон гэнэ (Цэрэнсодном Д. 1989, 82). Ийнхүү арц мод буюу арцыг Монголчууд ариун хэмээн шүтэж, одоо ч гэсэн гэр, орон сууц шинээр худалдаж авах, ариун зан үйлийг хийж гүйцэтгэх үедээ арцаар домнодог болжээ. Мөн энэхүү домгийг сонгож авсан гол шалтгаан бол бүх зүйлийг мөнх болгон хувиргах, ер бусын ямар нэг дээд шинж нь Сулхарнай нэрт хүнд ирж байгааг өгүүлж буйг мөн харгалзан үзсэн юм. Домог үлгэр хоёрын гол ялгаа бол домогт дээд, ер бусын ертөнцийн оршихуйтангууд энэ ертөнцөд буюу хүний ертөнцөд айлчлан ирдэг бол үлгэрт энэ ертөнцийн юмс, үзэгдэл нь гайхамшигийн, дээд, ер бусын ертөнцөд очдог юм.

Газар шүтлэгийн домог. Баруун Монголын нэгэн домогт *«Ховд аймгийн нутагт орших Хар-Ус нэртэй үзэсгэлэнт арал байдгийг Агвааш арал гэдэг. Эрт дээр цагт энэ нутагт хорин хүүхэдтэй өнөр өтгөн нэгэн айл аж төрөн амьдардаг байжээ.. Тэднийх энд олон жил нутаглаад нутаг сэлгэхээр болж, олон жижиг хүүхэдтэй учир тэр болгон зүслэн тогтооход бэрх байжээ». Ийм учир хүүхдүүдээ аягаар нь тоолдог байжээ. Хорин аяга тавин хооллол нэг аяга эзэнгүй хоцорч*

гэнэ. Нэг хүүхэд алга буйг мэдсэн аав, ээж, ах эгч нь ойр хавьдаа эрсэн боловч олсонгүй. Ингээд хуучин буйрнаа эргэж очтол Агваши нэртэй хүү нь буйран дээрээ уйлаад сууж байжээ. Ийнхүү энэ айлын нутаглаж байсан, хүүгийн уйлаад сууж байсан энэхүү арлыг “Агвашийн арал” хэмээн нэрлэх болжээ» (Катуу Б., Дашзэвэг Ч. 2003, 21) гэсэн байна. Энэхүү домог нь яагаад газар шүтлэгийн домог болж байгаа вэ гэхээр Агваши арал хэмээх энэ газар нь алга болсон хүүхдийг олж өгч байгаа дээд, ариун гэх шинжтэй юм.

Уул шүтлэгийн домог. Энд нэгэн домгийг мөн өгүүлэе. «Энэ уул нь Ховд аймгийн Эрдэнэбулган сумын нутагт байдаг...Эрт урьд цагт энэ нутагт Цамба гэж нэгэн анчин эр амьдардаг байжээ. Энэ уул урьд нь ямар ч усгүй ан амьтнаар элбэг, үзэсгэлэнт байгальтай, өндөр сүрлэг уул байжээ. Цамба ан гөрөөс намнаж явсаар нэг мэдсэн тэр уулын оройд гарчээ. Харин тэндээсээ бууж чадалгүй ардаа өнчин хоцорсон эхнэр, хүү хоёроо өрөвдөн уйлсаар нулимс нь мөнх цас болон тогтжээ. Цамба ийнхүү үхсэн учир нутгийн ард түмэн Цамбагарав гэсэн нэр хайрлаж үеийн үед тахин шүтэж иржээ»» (Катуу Б., Дашзэвэг Ч. 2003, 21) гэсэн байна. Энэ домгийг бид уул шүтлэгийн домгоор төлөөлүүлэн сонгож авсан нь нэгдүгээрт, энэ домог бол үлгэр биш, эмгэнэлт шинжтэй байна. Хоёрдугаарт, жирийн хүн энэ ууланд гараад эргэж ирэхгүй байгаа нь ер бусын шинжийг илтгэж байна. Энэ домог нь эко ёс суртахууны хувьд их сонирхолтой домог гэдгийг бид хэлэлцүүлгийн хэсэгт тодорхой дурдсан болно.

Амьтан шүтлэгийн домог. Бид домгийн философийн орчин арга зүйг үндэслэн амьтан шүтлэгийн дараах

домгийг түүвэрлэн жишээ болгож сонголоо. Үүнд, «Морь уг нь хүний гарт эдлэгдээгүй байх цагтаа хээр талаар онгон бэлчиж байжээ. Тэгсэн нэг удаа бугын сүрэг тэр зэрлэг адууны бэлчээрийг давтаж өвсий нь идсэнд адууны уур омог нь хүрч хойноос нь элдэж, хөөсөн боловч гүйцсэнгүй. Адуу бугыг хөөгөөд гүйцээгүйдээ улам хорсож түүнээс яаж өшөө хонзонгоо авах вэ? гэж хүнээс асуужээ. Хүн: - Чи миний амгай зуузайг дааж чадвал, би чамайг унаж өшөөг чинь авч өгч үзье гэв. Зэрлэг бугаас өшөөгөө л авбал бусад юм ч яах вэ гэж бодоод, хүний хэлснийг үг дуугүй дагасаар эмээл, хазаар тохуулж эдлүүлсэн хойноо бугаас өшөө авах гээд, хүний унаа болсноо сая ухаарч гэнэ. Хүн адуунд буганаас өшөөг чинь авч өгнө гэж хэлснээрээ бугыг намнадаг болсон юмсанжээ» (Цэрэнсодном Д. 1989, 86).

Ус шүтлэгийн домог. Ус шүтлэгтэй холбоотой домог бол уул, тэнгэр шүтлэгийн домгуудтай харьцуулахад харьцангуй бага бөгөөд усыг ихэвчлэн газар доорх ертөнц хэмээн үзэж хорио цээрийн ач холбогдолтой байж ирснийг дараах домогт тухайлбал “Эрт урд цагт Догишин хар лусын хаан усан дотор биш газар дээр байжээ. Тэр эр чадалдаа эрдэж, хүн амьтныг хөнөөж зовоосон аймишгт дайсан байлаа” (Цэрэнсодном Д. 1989, 146) гэсэн байна. Өөр нэгэн домогт “Эрт цагт нэг эмэгтэй бурхан хүүгээ үхүүлээд уйлж унжиж суухад нь нулимс нь гол мөрөн болоод урсаж байжээ” (Цэрэнсодном Д. 1989, 39) гэсэн байна.

Тэнгэр шүтлэгийн домог. Тэнгэр шүтлэгтэй холбоотой домгийн жишээ гэвэл Гэсэр, Жангар, Хан харангуй зэрэг туульд хүний энэ ертөнц дээр самуун цаг ирж улмаар тэнгэрийн хүү

Гэсэр энэ ертөнц дээрх ад муу чөтгөр зэрэг муу муухайтай тулалдахаар ирж буй тухай өгүүлдэг. Тухайлбал, *Ертөнц дээр самуун цаг болсон тул түүнийг засахаар Хурмаст тэнгэрийн хөвгүүн Үйл бүтээгч тэнгэрээс бууж Төвдийн Лин оронд Сэнлон ноёны хөвгүүн Гэсэр болж төрөв* (Дамдинсүрэн Ц. 1986) гэсэн байдаг. Ийнхүү хүн анх тэнгэр эцгээс угшилтайгаар газар эхийн хэвлийд төрсөн тухай домог бий болсон байна. Монголчууд ертөнцийг тэнгэрээс эхлэлтэй тухай домгийн сэтгэлгээ нь хожим Их монгол улсын үеийн гол түүхэн дурсгал болох Монголын нууц товчоонд тусгалаа олсон байдаг. Тухайлбал, “*Чингис хааны язгуур, дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ Чоно ажгуу...*” (Монголын нууц товчоо. 2009) хэмээн эхэлдэг.

IV. Хэлэлцүүлэг

Ургамлыг ариун хэмээн үзэж түүнийгээ дээдлэн шүтэж, хүсэл мөрөөдөл аз жаргалтай амьдралынхаа нэг хэсэг болгож ирсэн итгэл үнэмшил бол Монголчуудын домгийн сэтгэлгээнд тод томруунаар илэрч байдаг. Ургамал бол Монголчуудын эко ёс суртахууны гол шүтээн юм. Монголчууд бараг бүхий л ургамал, модыг хүнийг анагаах увидастай, ид шидийн хэмээн итгэж, дээдэлж, судалж, домог үлгэрийн гол субъект болгож иржээ.

Газар шүтлэг нь ерөнхийдөө цадиг (фетиш) шүтлэг, аним шүтлэгийн дундын байр суурийг эзлэх бөгөөд Монголчууд газрыг шүтэж, дахих үзэгдэл л мөн эрт дээр үеэс уламжлагдан ирсэн билээ. Ялангуяа, энэ нь Монголчуудын дунд тархсан газар усны домогт тусгалаа олсон байдаг. Хэл шинжлэлийн ухааны

эрдэмтэд Монголчуудын дунд дархаж ирсэн газар усны домгийг эмхтгэн нийтэлсэн байна. Б.Катуу, Ч.Дашзэвэг нар нь “Баруун Монголын домог, хууч яриа” гэсэн эмхтгэл бүтээлийнхээ оршилд “газар усны домог нь газар зүйн өвөрмөц сонин тогтоц, бүтэц, нэрийн учир холбогдлын тухай үнэн баримт, уран сэтгэмж хослуулан хүүрнэн өгүүлсэн аман зохиолын нэг төрөл” хэмээн тодорхойлсон байна. Мөн газар шүтлэгт бол газрын дээр доор байгаа бүхий л юмс үзэгдэл багтах бөгөөд үүнд, уул, ус багтах юм. Гэхдээ бид энэ удаа газар шүтлэг гэдэгт зөвхөн газрыг оруулж авч үзэхийг зорьж байгаа юм. Тухайн нэг газрыг ариун хэмээн үзэж, хүсэл мөрөөдлийнхөө илрэл хэмээн итгэж, шүтэж биширч хайрлаж хамгаалж ирсэн нь Монголын бараг бүхий л газар нутагт хамааралтай үзэгдэл хэмээн хэлж болох юм.

Газар шүтлэгтэй холбоотой баруун монголын жишиг домогт ямар нэг газар нутгийг ариун гэж үзэх үндэслэлийг гаргаж тавихыг оролдсон байна. Яагаад тухайн газар энд ариун болж байгаа вэ гэвэл нэгдүгээрт энэ газар олон хүүхэдтэй айл нутаглаж байсан. Монголчуудын уламжлалт ёс суртахууны үүднээс бол хүүхэд олонтой өнөр өтгөн айл бол ариун, сайн, сайхны бэлгэдэл юм. Мөн нөгөө талаас олон гэдэг бол Монголчуудын хувьд элбэг баян байхын бэлгэдэл юм. Тийм ч учраас энэ домог бол тухайн газар нутгийг ариун хэмээн шүтэн дээдлэхийн учир шалтгаан болж байна. Газрыг Монголчууд үржих, өсөх, дэвжихийн бэлгэдэл болгон шүтэж ирсний илрэл бол яах аргагүй энэ домог юм. Мөн энд эко ёс суртахууны ямар илрэл байна вэ гэхээр «Монголчууд олон жил нутагласан нутгаа эдлэгдэж,

өвс тэжээлийн доройтолд орохоос болгоомжилж нутгаа сэлгэдэг байсныг гэрчилж байна. Одоо ч энэ эко ёс суртахуун нь Монголын малчдын дунд байгаа зан байдал юм. Мөн газрын тухай эртний Монголчуудын үзлийг эрдэмтэн, философич Ч.Жүгдэр нь бичихдээ “Газрыг чингэж, амьдралын түгээмэл орчин, оршин ахуй гэж үзэх нь...” (Жүгдэр Ч., Дашпүрэв Д., Дашжамц Д, ба бусад 1997, 21) хэмээн бичсэн байна. Ийнхүү Монголчууд газрыг ариун дагшин амьдрал төдийгүй оршин ахуй хэмээн үзэж ирсэн нь тэдний эко философи, ёс суртахууны үндэс юм.

Уул толгод бүхэн Монголд өөрийн гэсэн домогтой. Монголчууд газар нутгаа ариун хэмээн шүтэж, хайрлаж бас хамгаалсаар ирснийг уламжлалаас бид харж болно. Тухайлбал, уул овоогоо дахин шүтэх, овооны тахилгын зан үйлийг Монголчууд жил бүр биш юм гэхэд, бороо хур ховор, ган гачиг нүүрлэх эрсдэлд орох үед гүйцэтгэдэг. Геоэкологийн сүүлийн үеийн судалгааны өгүүлэлд “1940 оноос хойш гантай жилүүд нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд ялангуяа 2000 оноос хойш үргэлжилсэн гантай жилүүд ажиглагдаж байна” (Galtbayar S., Myagmarsuren A., Munkhbat B, et al. 2022) гэжээ. Үнэхээр ч ган гачиг болох давтамж нь нэмэгдэж байгаа ийм нөхцөлд тухайн газар орны уугуул суугуул иргэдийнх нь итгэл үнэмшил соёлын эрхэд хүндэтгэлтэй хандах нь чухал болсоор байна. Овоо тахих ёс бол Монголчуудын хувьд эрт дээр үеэс улбаатай, аним шүтлэгийн нэг илрэл юм. Энэ нь хожим буддын шашинтай нэгдэн нийлж, лам нар овоо тахих зан үйлд оролцох болсон билээ. Уултай холбоотой домог Монголын ястан, угсаатан бүрт бараг мянга мянгаараа

байдаг билээ. Бид үүнээс яг эко зан байдал, ёс суртахууны шинжтэй домгийг олж үзэхийг зорьлоо. Энд бол баруун бүсийн Монголчуудын Буддын ёс суртахууны илрэл харагдаж байгаа бөгөөд ан хийж, амьтны амийг таслах бол арван хар нүглийн нэг байдаг тул ан хийсэн хүнийг тухайн уулын эзэн савдаг шийтгэжээ гэсэн санаа агуулагдаж байгаа юм. Тийм учраас дурдсан уул шүтлэгийн домог нь уулыг эзэнтэй, эзэн нь догшин юм шүү хэмээн болгоомжлуулж, уул усаа хамгаалж байгаагийн нэг илрэл болж байна. Мөн энд Монголчуудын уул усаа онгон тагшин ариун байлгах тухай хүсэл мөрөөдөл, төсөөлөл илэрч байгаа юм. Энэ домог нь уулыг ан амьтнаар элбэг, үзэсгэлэнт байгальтай, өндөр сүрлэг байх тухай төсөөлөл юм. Ер нь одоо ч гэсэн Монголын хөдөө нутгийн иргэд ууланд хүн амьтныг хэт их гаргаж явуулах дургүй байх хандлага байсаар байгаа юм.

Усны эздийг лус, лусын эзэн хэмээн нэрлэж, усанд бузар оруулсан, усны амьтан ургамалд хор хүргэсэн хүнд хэрэв муу зүйл тохиолдвол лусын хорлол болжээ хэмээн тайлбарлах нь элбэг тохиолддог. Усны эзэн нь догшин байдаг нь бүр их сонин үзэгдэл юм. Лусын хорлол бол ихэвчлэн хүний хөл, тулгуур эрхтэнд нь нөлөөлдөг явж чадахгүй болгодог, бүр цаашилбал амь насанд нь халтай байдаг ч гэсэн итгэл үнэмшил байдаг. Энэхүү итгэл үнэмшил нь орчин үед бол цэнгэг цэвэр усыг хэмнэж амьдрах хүн нийгмийн эко ёс суртахууны үндэс хэмээн үзэж болох юм. Экологийн судлаачид химийн хортой элементүүдийг агуулсан ус хүний биед хорт хавдар үүсгэдэг тухай өгүүлсэн байна. Тухайлбал, “Ураны агууламж бүхий ундны ус нь хүүхдүүдийн хувьд хавдрын эрсдэл

үүсэх магадлал зуун мянган хүүхэд тутамд 1-2 хүүхэд, насанд хүрэгчдийн хувьд арван мянган насанд хүрсэн хүн тутамд 2 хүн өртөх магадлалтай байна” (Gantsetseg U., Batdelger O., Badrakh R., et al 2022) хэмээн бичсэн байна. Усыг хайрлаж, хамгаалах ёс суртахууны нэг жишээ бол загасыг тохирох үед нь зохих хэмжээгээр агнах юм.

Амьтан шүтлэгийн домог нь Монголчуудын дунд түгээмэл тархсан юм. Аливаа нэг амьтныг ариун шүтээн хэмээх үзэл ойлголт бол аман зохиолын уламжлалд элбэг тохиолддог. Энэ тухай Монголын философийн түүхийн-1 дүгээр ботид эрдэмтэн философич Д.Дашжамц бичсэн байдаг. Тухайлбал, тэрээр бичихдээ “Ардын аман аман зохиолд эн тэргүүнээ байгалийг дээдлэх үзэл санаа эн тусаж байжээ” (Жүгдэр Ч., Дашпүрэв Д., Дашжамц Д, ба бусад 1997, 153) гэсэн байна. Амьтан шүтлэгийн домгийн хувьд монголчууд газар доор байх амьтдыг лус савдагийнх хэмээн үзэж, шүтэхээсээ илүү айдаг, цээрлэдэг байж. Шувуу гэх мэт тэнгэрийн амьтдыг тэнгэрийнх хэмээн үзэж дээдлэн шүтдэг байжээ. Харин буга, чоно гэх мэт газрын амьтдыг энэ ертөнцийнх хэмээн үзэж дээд дунд ертөнцийн зуучлагч байдлаар үздэг байв. Харин энэ дундаас морийг тэнгэрлэг хийморлог хэмээн итгэж бишрэн шүтсээр ирсний жишээ бол дээрх домог юм. Орчин үед бол байгаль хүн нийгэмд ээлтэй амьтдыг илүү тоогоор үржүүлэх хүрээлэн буй орчны ёс суртахуун зонхилох хандлагатай байгаа бөгөөд эсрэгээрээ байгальд хор хөнөөлтэй амьтдын тоо толгойг багасгах зайлшгүй шаардлага ч бас тулгарч байна. Монгол орны хувьд сүүлийн

жилүүдэд ган гачиг ихсэж, хур бороо багасаж байгаатай холбоотой царцаа, хар хорхойны нүүдэл ихсэж байгаа эко асуудал тулгарч байна. Тухайлбал, экологийн судлаачид энэ тухай судалгаа хийж “Бид өөрсдийн судалгаа болон хэвлэлийн мэдээ баримтыг нэгтгэн төвийн бүсийн нутгаас хөнөөлт зүйлийн царцааны нийт 4 дэд овгийн 10 трибийн 21 төрөлд хамаарах 25 зүйлийг бүртгэлээ” (Enkhzaya S., Altanchimeg D., Suvdtsetseg S. 2023, 99–108) гэсэн дүгнэлтийг хийжээ.

Тэнгэр шүтлэгийн тухай бичсэн бүтээл бол юуны өмнө Монголын философийн түүх-I боть билээ. Энэхүү ном нь 1990 -ээд оны үе дэхь Монголын философич эртэмтэдийн хамтын бүтээл юм. Номын хоёрдугаар бүлэг нь Эртний Монголчуудын домог-шүтлэгийн сэтгэлгээний онцлог гэсэн нэртэй бөгөөд энэ зүйлд хүрээлэн буй орчинтой нэгэн чухал ойлголтыг “тэнгэр” хэмээн үзсэн байна. Энд бичихдээ “Хүрээлэн буй байгаль орчныг үүсгэн бүтээгч нь “туурвигч тэнгэр” нар боловч байгаль өөрчлөгдөн хувьсаж байдаг гэсэн үзэл санаа эртний Монголчуудын ертөнцийг үзэхүйд агуулагдаж байжээ” (Жүгдэр Ч., Дашпүрэв Д., Дашжамц Д, ба бусад 1997, 56) хэмээн бичсэн байна. Энэ нь Монголчуудын ардын аман зохиолд тусгалаа олсныг жишээ татан бичсэн байна. Өнөө үед ч гэсэн Монголчууд тэнгэртээ сүслэн, долоон бурхан одонд хүслээ шивнэн сүү сааль идээнийхээ дээжээс өргөдөг уламжлалаа хадгалсаар байна.

Монголчуудын хүрээлэн буй орчны ёс суртахууны үндэс болсон байгаль шүтлэгийн домгийн сэтгэлгээ бол экологийн орчин үеийн асуудлуудыг шийдэхэд харгалзаж үзэх ёстой итгэл үнэмшил, хүсэл мөрөөдлийн

тогтолцоо юм. Үүнтэй холбоотойгоор Монгол соёлын оршин тогтнох эрх, байгаль орчноо хамгаалах, ухаалгаар байгалийн нөөцийг ашиглах зэрэг зорилгын үүднээс Монголын газар нутагт амьдарч буй Монголчууд гэх ард түмний эко ёс суртахууныг зайлшгүй мэдэж, хууль эрх зүйн тогтолцоо, менежментийн ухаанд тусгах нь чухал юм. Бид судалгааны дээрх үр дүнд үндэслэн орчин үеийн Монголчуудын байгаль шүтлэгийн эко ёс суртахууныг структурализм, соёлын философи, экологи, географи зэрэг байгалийн шинжлэх ухааны, социологи, шашин судлал, хэл шинжлэл зэрэг нийгэм-хүмүүнлэгийн шинжлэх ухааны гэх мэт салбар дундын аргуудыг хослуулж судлан шинжлэх нь зүйтэй гэсэн

Ашигласан материал

- Дель Ж., Пано Карпини, Вильгелм де Рубрук. 1988. *Монголчуудын түүх. Дорнод этгээдэд зорчсон минь.* Хянасан орчуулгын ред. Шагдарсүрэн Ц. Орчуулсан Цолмон С., Туяа С. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Рамузио. 2019. *Марко Пологийн аялал (1559 оны хувилбар).* Edited by Мөнхбат Ё. орчуулгын ред. Ганбаатар Ж. Элизабетта Рагагнин., ба бусад. Орч. Бат-Учрал Г. Улаанбаатар: “Соёмбо принтинг” ХХК.
- Марсель Мосс. 2000. *Социальные функции священного /Избранные произведения.* Translated by (Перевод и французского под общей редакцией) Утехина И.В. СПб. “Евразия”.
- Жүгдэр Ч. 2006. *Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил (МЭӨ III-МЭ ХХ зуун).* Улаанбаатар: “Бэмби сан” хэвлэлийн газар.
- Института философии, РАН. 2024. *iphlib.ru.* Нэвтэрсэн 2024 оны August 31. <https://iphlib.ru/library/collection/newphilenc/document/>

дүгнэлтэд хүрч байна. Тухайлбал, тухайн бүс нутагт шүтлэгийн зан үйл хийхдээ хог хаягдлаа хэрхэн шийдвэрлэж байна; мөргөлийн зан үйл хийж байгаа хүмүүс байгальд ээлтэй бүтээгдэхүүн хэрэглэж байна уу; зан үйл гүйцэтгэх үедээ тухайн нутаг орныхоо эко хүнсийг хэрэглэж байна уу гэх зэрэг үзүүлэлтээр нь бүс нутгуудыг гүехэн ногоон, ногоон, гүн ногоон хэмээн ангилж авч үзэх юм. Ингэхдээ Буддын, Христийн, Лалын гэх мэт институтийн шашнуудыг төдийгүй, уул, ус, тэнгэр, газар, ургамал шүтлэг зэрэг уугуул шашнуудын хүрээнд мөн авч үзэх юм. Монгол бол олон шашин зэрэгцэн оршсоор ирсэн олон соёлын орон билээ.

HASH0155bae87c519c2e6089cb55-ээс Гаргасан.

- Цэвэл Я. 1966. *Монгол хэлний товч тайлбар толь.* (30000 орчим үг). Edited by ред. Лувсанбалдан Х. Улаанбаатар: БНМАУ, ШУА, Хэл зохиолын хүрээлэн. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо.
- Susanne Langer. 1942. *Philosophy in a new key. Study in the symbolism of reason, rite, and art.* Cambridge: Harvard university press.
- Элиаде Мирча. 1995. *Аспекты мифа. Пер. С фр. В.Большакова.* СПб: Инвест-ППП.
- Цэрэнсодном Д. 1989. *Монгол ардын домог үлгэр.* Edited by Шүгэр Ц., ред. Сампилдэндэв Х. Улаанбаатар: Хэл зохиолын хүрээлэн, ШУА, Улсын хэвлэлийн газар.
- Кагуу Б., Дашзэвэг Ч. 2003. *Баруун Монголын домог, хууч яриа.* ред. Сампилдэндэв Х. Улаанбаатар: Хэл зохиолын хүрээлэн, ШУА, “Бэмби сан” хэвлэлийн газар.

- Дамдинсүрэн Ц. 1986. *Гэсэр*. Улаанбаатар: Хэл зохиолын хүрээлэн, ШУА.
2009. *Монголын нууц товчоо*. Улаанбаатар. Жүгдэр Ч., Дашпүрэв Д., Дашжамц Д, ба бусад. 1997. *Монголын философийн түүх. I дэвтэр*. Улаанбаатар: Философийн хүрээлэн, ШУА.
- Galtbayar S., Myagmarsuren A., Munkhbat B, et al. 2022. “Determining variables of social, economic, and ecological vulnerability to climate change.” *Mongolian Journal of Geography and Geoecology* 59 (43): 30-42.
- Gantsetseg U., Batdelger O., Badrakh R., et al. 2022. “Assessment of uranium concentration in drinking water: (A case study in the western soums of Tov province).” *Mongolian Journal of Geography and Geoecology* 59 (43): 129–135.
- Enkhzaya S., Altanchimeg D., Suvdtsetseg S. 2023. “Diversity and species composition of harmful grasshoppers in Central Mongolia” *Proc. Inst. Biol.*, 39 (2): 99–108.